

**УЛААНБААТАР ЧУУЛГЫН 2019 ОНЫ ЖИЛИЙН  
ЭЦСИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**



**УЛААНБААТАР  
ЧУУЛГА**

**УЛААНБААТАР ХОТ  
2019**

## ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, АГУУЛГА

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- 1.1 “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл
- 1.2. Төрөөс баримтлах бодлогод заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүн;
- 1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл
- 1.4. Улсын болон Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын хэрэгжилт;
- 1.5 Дэд хөтөлбөрт тусгасан, тухайн байгууллагаас гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл
- 1.6. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт;

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- 2.1. УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн нийслэл болон тухайн байгууллагуудад холбогдолтой заалтын хэрэгжилт;
- 2.2. Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт;

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- 3.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн биелэлт;
- 3.2. Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа;
- 3.3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлсэн байдал;
- 3.4. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл;
- 3.5.Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт;
- 3.6. Архив албан хэрэг хөтлөлт;
- 3.7. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа;
- 3.8.“Нийслэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д 2019 онд гаргасан тайлан, мэдээ;

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

- 4.1. Мэдээллийн үйл ажиллагааны ил тод байдал;
- 4.2. Төсөв, санхүүгийн ил тод байдал;
- 4.3. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал;
- 4.4. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт;

### ТАВДУГААР БҮЛЭГ. НИЙСЛЭЛИЙН ХҮН АМД ҮЗҮҮЛЭХ СОЁЛ, УРЛАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ЧАНАРТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 5.1. Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;
- 5.2. Байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай;
- 5.3. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээлэл;
- 5.4. Хөрөнгө, санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт;
- 5.5. Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, чанартай зохион байгуулах зорилтын хүрээнд хийгдсэн ажил;

## **“УЛААНБААТАР” ЧУУЛГЫН 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

2019 оны 12 дугаар сарын 25

2019 оны жилийн эцсийн Монгол улсын Засгийн газрын тогтоол болон НИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засгийн зорилтод тухайн жилд тусган дэвшүүлсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон Нийслэлийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан ажлын төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг зохион байгуулан ажиллав.

### Нэгдүгээр бүлэг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн”

#### **1.1 “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл**

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д заасан хэрэгжилтийн хүрээнд Улаанбаатар чуулга нь 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 2 сарын хугацаанд өдөр бүр 18.00 цагаас өөрийн тайзнаа “Анхаа трэйвэл”, “Үж Хан” ХХК, “Мини Тоувер” ХХК, “Эм Би Зэт Ай” ХХК зэрэг аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудтай хамтран гадаадын жуулчдыг татах зорилгоор ардын урлагийн “Color’s of Mongolia” тоглолтыг жуулчдад үзүүлж ажилласан. Цаашид чанараа дээшлүүлж, бусад театр чуулгуудын тоглолтоос өвөрмөц нүүдэлчдийн ахуйн соёлыг харуулсан үзэсгэлэн, цаасан хайчилбарын урлал, калиграф бичгээр дурсгалын нэрээ бичүүлэх, дурсгалын зураг авахуулах зэрэг соёлын үйлчилгээг цогцоор нь үзүүлэх тал дээр анхаарал хандуулан ажиллаж байна.

#### **1.2 Төрөөс баримтлах бодлогод заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүн**

**Үндэсний соёл урлагийг дэлхий нийтэд сурталчлан таниулах, монгол соёлын нөлөөллийг өргөжүүлэх, давтагдашгүй чанарыг баталгаажуулах зорилтын хүрээнд;**

Нийслэлийн Улаанбаатар чуулга нь НЗДТГ, Нийслэлийн Аялал жуулчлалын газартай хамтран аялал жуулчлалын томоохон үзэсгэлэнгийн үйл ажиллагаанд оролцож, Монголын ардын урлаг, соёл, өв уламжлалыг харуулсан соёлын биет болон биет бус өвийн үзүүлэх тоглолт бүхий бэсрэг концертыг бэлтгэн, гадаадын болон өөрийн орны иргэдэд зориулсан Улаанбаатар хотыг сурталчлах ажлуудад идэвхтэй оролцсон.

#### **1.3 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр **1.4.1, 5.1.2, 4.3.5, 1.6.1** дахь заалт буюу 4 ажил тусгагдсанаас 2019 оны жилийн эцэст Улаанбаатар чуулга 100 хувийн хэрэгжилттэй байна.

*1.4.1 Зүүн хойд Азийн бизнес, соёлын болон дамжин өнгөрөх жуулчлалын төв болно.*

Нийслэлийн Аялал жуулчлалын газартай хамтран аялал жуулчлалын томоохон үзэсгэлэнгийн үйл ажиллагаанд оролцож, Монголын соёл, өв уламжлалыг харуулсан соёлын биет болон биет бус өвийн үзүүлэх тоглолт бүхий бэсрэг концертыг бэлтгэн,

гадаадын болон өөрийн орны иргэдэд Улаанбаатар хотыг сурталчлах ажлыг зохион байгуулна.

*Зорилтын хүрээнд:* Нийслэлийн Аялал Жуулчлалын Газартай хамтарч гадаад дотоодын EXPO, үзэсгэлэнгийн үйл ажиллагаанд оролцож Турк, ХБНГУ, ОХУ-ын Иркутск хот, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот, Улаанбаатар хотын Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд болсон “Улаанбаатар травэл экспо-2019” үзэсгэлэнгийн үйл ажиллагаанд оролцож, гадаад дотоодын 10000 орчим үзэгчдэд хүрч үйлчлэн, үндэсний өв соёлоо таниулан сурталчилсан.

*5.1.2 дахь заалт Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт"-ээр үнэлэхэд хүний нөөцийн бүртгэл төлөвлөлтийн /ERP/ системийн мэдээллийн санг ашиглаж, хүний нөөцийн чадавхыг хөгжүүлнэ.*

*Зорилтын хүрээнд:* Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг улирал бүр хийж захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн, ур чадварын нэмэгдэл хөлсийг олгож хэвшсэн. Ингэхдээ ялангуяа уран бүтээлчдийн тоглолтонд оролцсон давтамж, ажлын ачаалал тооцох хүснэгтээр ачааллыг эрэмбэлж тооцдог бөгөөд хурууны хзэгээр бүртгэх бүртгэлийг мөн энэ ачааллын хүснэгттэй уялдуулан тооцдог. Мөн мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн, урын сангаа баяжуулсан, мэргэжлийн ур чадварын уралдаан тэмцээнд оролцсон зэргийг харгалзан тооцсон.

*4.3.5 "Аз жаргалтай хот" соёл урлагийн цогц арга хэмжээ зохион байгуулж, Улаанбаатар хотын нэрийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.*

*Зорилтын хүрээнд:* "Аз жаргалтай хот" хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан "Дээлтэй Монгол", "Даншиг Наадам", "UB food", "Улаанбаатар" аялал жуулчлалын үзэсгэлэн, "Тал нутгийн марафон", Улаанбаатарын "Өвлийн наадам", "Цасны баяр" зэрэг арга хэмжээнүүдэд хамт олноороо идэвхтэй оролцож, ард иргэдэд ардын болон орчин цагийн урлагийг таниулан сурталчлах ажилд мэргэжлийн урлагийн байгууллагуудыг манлайлан оролцсон.

*1.6.1 Нийслэлийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлнэ*

Байрны өмч ашиглалтыг сайжруулах замаар, үргүй зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, нийслэлийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг дахин хийлгэх, хандив тусламжаар ирсэн эд хөрөнгийг бүртгэн мэдээллийн санд оруулах зэрэг ажлуудыг зохион байгуулж ажиллана.

*Зорилтын хүрээнд:* Зардлыг батлагдсан сар, улирлын хуваарьт багтаан зарцуулан үйл ажиллагаагаа явуулж, өр төлбөр үүсгэлгүй хэмнэж ажиллаж байна.

#### **1.4. Улсын болон Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын хэрэгжилт**

2019 онд улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажил тус чуулгад байхгүй болно.

## 1.5. Дэд хөтөлбөрт тусгасан, тухайн байгууллагаас гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл

### Монгол цуурын хөгжмийг өвлүүлэн үлдээх

Монгол цуурын хөгжмийн уламжлалт урлаг нь Хүннүгийн үеэс өвлөгдөн ирсэн гайхамшигт хөгжмийн зэмсэг билээ. Цуур нь 3 нүхтэй, уртааш барьж үлээдэг модон үлээвэр хөгжмийн зэмсэг юм. Цуурын хийц нь энгүүн эгэл мэт боловч нүүдэлчин, малчин, анчин Монголчуудын олон зууны туршид ухамсар зорилготойгоор үүсгэн бүтээж, хөгжүүлж ирсэн өвөрмөц бүтээл юм. Цуур хэдийгээр 3-хан нүхтэй боловч байгаль, дэлхий, уул усны чимээ, хөг аялгуу түүний гоо үзэсгэлэн, сүр жавхлан, ан амьтны дүр байдлыг илэрхийлэхдээ 12 өргийн эгшиглээ орчин цагийн зэмсгээс дутуугүй.

Цуур хөгжмийн уламжлалт урлаг нь Монгол улсын соёлын биет бус ховор хосгүй өвийн зэрэглэлд багтдаг бөгөөд 2009 онд ЮНЕСКО-гоос яаралтай хамгаалах шаардлагатай соёлын өвийн Дэлхийн жагсаалтад бүртгэн тунхагласан болно.

Улаанбаатар чуулга төрөөс баримтлах соёлын бодлого, хууль тогтоомжид монгол үндэстэн, угсаатан, ястны өв соёл, ёс заншлыг хадгалан хамгаалах, харилцан баяжуулах асуудлын хүрээнд “Морин хуур хөгжим, уртын дуу”, “Хөөмэй”, “Бий биелгээ” залуу үед өвлүүлэн эзэмшүүлэх, хадгалан хамгаалах зорилгоор хүүхэд залуусын дунд сургалтуудыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Чуулгын уран бүтээлч Битбокс Рей /Нарандэлгэр/, Монголын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран "СОЁЛЫГ ТҮГЭЭЭ" нэртэй арга хэмжээг өсвөр насны охидууд болон ээж нарт зориулан орон нутгуудаар хийлээ. "СОЁЛ ТҮГЭЭХ" бол зөвхөн өв соёл, биет бус өв соёлын үнэ цэнэ бус харин олон нийтэд мэдлэг, мэдээлэл олгох, сургах хөгжүүлэх юм. Энэхүү ажлыг Монголын 21 аймгаар хийх төлөвлөгөө гарган ажиллаж байна.



**1.6. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт;**

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд соёл, урлагийн чиглэлээр нийт 18 ажил төлөвлөгдсөн бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 100%-ийн гүйцэтгэлтэй байна

[Хоёрдугаар бүлэг: “Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн”](#)

**2.1 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дүн**

**а/** Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн дагуу нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын хүрээнд Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон тайлан мэдээг цаг тухай бүр нь хэрэгжүүлж ажиллаж байна.

**Хүснэгт 1**

		Нийт	МУ-ын хууль	МУ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ҮАБЗ-ын зөвлөмж, тэмдэглэл	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгч
Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо						1		2		2		1
Хяналт авсан нийт зүйл заалтын тоо						1		2		2		1
Бүрэн хэрэгжсэн	100%					1		2		2		1
Хэрэгжих шатанд	70%											
Хэрэгжилт хангалтгүй	30%											
Хэрэгжээгүй	0											
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй												
Биелэлтийн дундаж						100%		100%		100%		100%

**б/ Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт**

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр захирамжийн хэрэгжилт:

Тус захирамжаар 2019 оныг “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил” болгон зарласны дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тухайн жилд хэрэгжүүлэх үйл

ажиллагааны төлөвлөгөөнд санал тусган боловсруулах ажлын хүрээнд Улаанбаатар чуулга дараах 2 ажлыг боловсруулж хүргүүлсэн.

1. Нийслэл хотыг тойрсон орон нутаг болон нийслэлийн алслагдсан дүүргийн ард иргэдэд хүрч үйлчлэх замаар орлого нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулна.

2. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан тайлбарт тоглолтуудыг зохион байгуулах.

Энэхүү ажлуудын биелэлтийн мэдээг улирал бүр гарган Нийслэлийн Засаг даргын Төрийн Захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлж ажилласан.

*2. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/09 дүгээр захирамжийн хэрэгжилт:*

2018 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн үнэлгээний дүнд тус чуулга нь “**ХАНГАЛТТАЙ**” гэсэн үнэлгээ авсан бөгөөд ажлын хүрээнд 5 ажлыг сайжруулж дэвшилттэй ажилласан ба анхаарч ажиллах 8 зөвлөмж ирсний дагуу төлөвлөгөө гарган холбогдох албан хаагч нарт үүрэг өгч мэдээг НЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлж ажилласан.

*3. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/76 дугаар захирамжийн хэрэгжилт:*

Томуугийн вирусын халдварын тархалт Нийслэлийн нутаг дэвсгэрт нэмэгдэж, цаашид нөхцөл байдал хүндрэх тархвар судлалын эрсдэл үүсэхгүй, хавдрын эрсдлийг бууруулах зорилгоор олон нийтийн арга хэмжээнд Улаанбаатар чуулга нь 0-10 хүртлэх хүүхдэд үйлчлэхгүй байх арга хэмжээг 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл мөрдөг болгон ажилласан.

*4. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/85 дугаар захирамжийн хэрэгжилт:*

2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 98 жилийн ойд зориулсан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабийн “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах-төрийн батлан хамгаалах үйлчилгээний өдөрлөг”-ийг соёлын төв өргөөнд зохион байгуулах ажлын хүрээнд Улаанбаатар чуулгын уран бүтээлчид ая дуугаа өргөж оролцсон.

*5. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/243 дугаар захирамжийн хэрэгжилт:*

Нийслэлийн Засаг даргын А/88 дугаар захирамжийн дагуу 2019 оны 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-д чуулгын захиргааны 10, тайз техникийн 8 албан хаагч тус захирамжийг мөрдөж ажилласан.

*6. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/337 дугаар захирамжийн хэрэгжилт:*

Нийслэлийн Засаг даргын А/88 дугаар захирамжийн дагуу 2019 оны 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-д захиргааны 10, тайз техникийн 8 албан хаагч түр цуглах талбайд гарч тус захирамжийг мөрдөж ажилласан.

*7. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/338 дугаар захирамжийн хэрэгжилт:*

Нийслэлийн хэмжээнд 2019 оны 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн хүрээнд иргэд түр цугларах талбайд гарч, дадлага сургуульд оролцохтой холбогдуулан 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр нийслэлийн төр, захиргаа болон аж ахуй нэгж байгууллагын ажил эхлэх цагийг 10 цаг 00 минут, дуусах цагийг 19 цаг 00 минут байхаар шийдвэр гарсантай холбогдуулан хүний нөөцийн менежер Л.Одгэрэл албан хаагч нарт мэдээлэл хүргүүлэн мэдээллийг хэрэгжүүлж ажилласан.

*8. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/339 дугаар захирамжийн хэрэгжилт:*

Нийслэлийн хэмжээнд 2019 оны 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн хүрээнд иргэд түр цугларах талбайд гарч, дадлага сургуульд оролцохтой холбогдуулан 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр нийслэлийн төр, захиргаа болон аж ахуй нэгж байгууллагын ажил эхлэх цагийг 10 цаг 00 минут, дуусах цагийг 19 цаг 00 минут байхаар шийдвэр гарсантай холбогдуулан хүний нөөцийн менежер Л.Одгэрэл албан хаагч нарт мэдээлэл хүргүүлэн мэдээллийг хэрэгжүүлж ажилласан.

*9. Нийслэлийн засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/417 дугаар захирамжийн хэрэгжилт:*

Дулааны улирал эхэлж, өдөр уртсаж байгаатай холбогдуулан ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, авто замын ачааллыг зохицуулах зорилгоор 2019 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл ажлын цагийг өглөө 8 цаг 00 минутаас орой 17 цаг 00 цаг болгон ажиллах болсонтой холбогдуулан чуулгын нийт албан хаагчид захирамжийг мөрдөж, хүний нөөцийн менежер түүнд хяналт тавин ажилласан.

*10. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/333 дугаар захирамжийн хэрэгжилт:*

Төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламж болон бусад эх үүсвэрээр тухайн онд зохион байгуулах худалдан авах ажиллагаа энэ онд Улаанбаатар чуулгад байхгүй болно.

*11. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/395 дугаар захирамжийн хэрэгжилт:*

Нийслэлийн Засаг захиргааны 5-р байрны А корбус буюу Улаанбаатар чуулгын байрны хяналтын камерууд болон түүнд хяналт тавих чиг үүрэг нь Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт харьяалагддаг болно.

*12. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/438 дугаар захирамжийн хэрэгжилт:*

“Автомашингүй өдөр-2019” өдөрлөгийг “Эрсдэлгүй-Эрүүл орчныг хамтдаа” уриан дор зохион байгуулагдсан тус арга хэмжээг албан байгууллагаараа мөрдөж ажилласан ба Жанжин Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан үйл ажиллагаанд уран бүтээлчид бүрэн бүрэлдэхүүнээрээ урлагийн тоглолт үзүүлж ажилласан.

*13. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/475 дугаар захирамжийн хэрэгжилт:*

2019 оны 6-р сарын 5-10-ны хооронд байгууллагын албан хаагч нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, Лабораторийн шинжилгээг Эрүүл мэндийн даатгалын гэрээт байгууллага болох "Өнөр Үжин" ХХК-нийн лаборатори, нарийн



мэргэжлийн эмч нарын үзлэгийг Этүгэн Их сургуулийн эмч нарын баг, сургалтыг мөн Этүгэн их сургуультай хамтран зохион байгуулж ажилласан.

14. *Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/518 дугаар захирамжийн хэрэгжилт:*

2019 оны 07 дугаар сарын 01-ний А/13 дугаар тушаалаар улсын үзлэгт бэлтгэх ажлыг зохион байгуулах комиссыг дарга Р.Мөнхсайханаар ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

2019 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар чуулгад архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг 3-н хүний бүрэлдэхүүнтэй ирж төлөвлөгөөний дагуу үзлэг явуулсан. Тус үзлэгт 89% “В” дүнтэй шалгагдсан.

#### Гуравдугаар бүлэг: “Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт үр дүн”

### **3.1 Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт:**

1. *Чуулгын уран бүтээлчдийн ур чадварыг дээшлүүлж, шинэлэг хэлбэрийн урсгал чиглэлээр гоцлоочдын хамтарсан уран бүтээл туурвих сэтгэлгээг дэмжин, гоцлол дуучид, гоцлол хөгжимчдийн тайлан тоглолтыг зохион байгуулах, шинэчлэн найруулсан “Color`s of Mongolia -5” ардын урлагийн тоглолтоо ард иргэддээ өргөн барина.*

2019 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Нийслэлийн Улаанбаатар чуулга Говь-Алтай аймгийн нутгийн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан цусны хорт хавдартай 5 настай М.Энхжин охины хандивын тоглолтонд манай уран бүтээлчид бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож эмчилгээнд нь хандив өргөсөн.

2019 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр чуулгын гоцлол дуучин, МУСТА М.Анхтуяа “Тэгш дүүрэн жаргалтай яваарай” тоглолт, 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Монгол цэргийн бахархлын өдөрт зориулсан дуучин, СТА Ж.Буянтогтох “Ижилгүй монгол орон” тоглолт, 2019 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн бүжигчин Ж.Номгонмаа “Тэргэнцэртэй бүжигчин” тоглолт, 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 2-сарын хугацаанд өдөр бүр 18 цагаас гадаадын жуулчдад зориулсан “Color`s of Mongolia” тоглолтыг өөрийн тайзнаа “Анхаа трэйвэл” ХХК, “Үж Хан” ХХК, “Мини Тоувер” ХХК, “Эм Би Зэт Ай” ХХК -тай хамтран зохион байгуулж ажилласан.

2. *Архи, тамхигүй орчин бүрдүүлсэн хамт олон байж, үйлчлүүлэгчдэд зориулсан хувийн соёлын талаар сурталчилгаа, санамж, сануулах хуудсуудыг тодорхой байршлуудад байрлуулан, түүний дагуу хяналт тавьж байгууллагын соёлыг хэвшүүлнэ.*

Тус чуулга нь үзвэр үйлчилгээ, үйл ажиллагааны өмнө “Тамхины хяналтын тухай” хууль гарсантай холбогдуулан үзвэрийн өмнө үзэгчдийн танхим, чуулгын байранд утаат тамхи татах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглосон анхааруулга, санамж бүхий аман сурталчилгааг тогтмол хийдэг бөгөөд зурагт наалтуудыг шаардлагатай газруудад байршуулан ажилладаг.

3. *Байгууллагын “Бизнес төлөвлөгөө -2019” -ыг боловсруулан, урын сан дах бүтээлүүдээ олон нийтэд хүргэх пиар ажлуудыг төлөвлөж, шилдэг энтертайнмент компаниудтай хамтарч ажиллах замаар байгууллагын маркетингийн үйл ажиллагааг*

*сайжруулж, төлөвлөсөн уран бүтээлүүдийг мэдээллийн бүхий л сувгийг ашиглан олон нийтэд хүргэнэ.*

2019 оны Байгууллагын "Бизнес төлөвлөгөө" -г боловсруулан, урын сан дах бүтээлүүд болон шинээр тавигдах тайзны уран бүтээлүүдийг чуулгын даргаар батлуулж, түүний пиар ажлуудыг бүтээл тус бүрээр төлөвлөж, ACE энтертайнмент, V studio-тай хамтарч ажиллах замаар тоглолтын талаарх мэдээллийг телевизийн 6 суваг, FM-ийн 3 суваг, 5 веб сайтаар дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан.

*4. Албан хаагч, уран бүтээлчдийн ур чадварын аттестатчлалын шалгалт авч, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, Удирдах албан хаагчдын манлайлах чадавхийг хөгжүүлэхэд анхаарч ажиллах, тэдэнд зориулсан сургалтуудыг системтэй зохион байгуулах.*

Уран бүтээлчдийн аттестатчлалын удирдамжийг боловсруулж, тус шалгаруулалтыг нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, өөрийн уран бүтээлчдэд болон сошиал сувгаар мэдээллийг сонирхож буй бүлэгт хүргэж, удирамжийг танилцуулан бэлтгэл ажлыг хангаж, 2019 оны 4 дүгээр сарын 05-ний өдөр уран бүтээлчдийн чанар чансааг дээшлүүлэхээр нээлттэй сонгон шалгаруулалтыг явуулсан. Энэхүү сонгон шалгаруулалтад Улаанбаатар чуулгын үндсэн уран бүтээлч 30, гаднаас бүртгүүлж шалгуулсан 33 уран бүтээлч, нийт 63 уран бүтээлч оролцсон бөгөөд тэднийг чуулгын уран бүтээлчдийн үндсэн мэргэжил болох бүжигчин, дуучин, үндэсний хөгжимчний төрлүүдээр тусгайлан бэлтгэсэн даалгаврын дагуу шалгаруулалтыг явуулсан.

*5. Байгууллагын төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагналын мэдээллийг өөрийн байгууллагын вэб сайт, шилэн данс, аудит болон төрийн сангийн сайтанд байршуулах.*

2019 оны жилийн төсөв, сар улирлын тайлан мэдээ, холбогдох баримтууд, 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтийг хуулийн хугацаанд нь мэдээллийг өөрийн байгууллагын вэб сайт, шилэн данс, сангийн яамны сайтанд байршуулж иргэд олон нийтэд нээлттэйгээр мэдээлсэн.

*6. Чуулгын урын санг баяжуулах зорилгоор улирал бүр нэгэн шинэ бүтээлийг найруулан өөрийн тайзнаа тавьж, чуулгын уран бүтээлчдийн нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглаж ажиллах.*

2019 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр чуулгын гоцлол дуучин, МУСТА М.Анхтуяа “Тэгш дүүрэн жаргалтай яваарай” тоглолт, 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Монгол цэргийн бахархлын өдөрт зориулсан дуучин, СТА Ж.Буянтогтох “Ижилгүй монгол орон” тоглолт, 2019 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 18.00 цагаас бүжигчин Ж.Номгонмаа “Тэргэнцэртэй бүжигчин” тоглолт, 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Нийслэл хот үүсэн байгуулагдсаны түүхт 380-н жилийн ойн хүрээнд "ИХ ХОТЫН АЯЛГУУ" тоглолтыг Улаанбаатар чуулгын уран бүтээлчид нийслэлд сурч, хөдөлмөрлөдөг нийт иргэддээ зориулан тоглосон. 2019 оны 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар 01-ний өдөр “Маугли” хүүхдийн циркчилсэн тоглолт, 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн үндэсний хөгжмийн “Хангарьд” найрал үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойн “Хүндэтгэлийн тоглолт” зэргийн бичлэгийг мэргэжлийн түвшинд хийж, байгууллагын архивт хадгалсан.

*7. Байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах гол хэрэглүүр болох веб сайтын бүтцийг шинэчилж, санхүүгийн, хүний нөөцийн, байгууллагын үндсэн үйл ажиллагааны ил тод байдлын талаар тогтмол мэдээлж, сошиал мэдээллийн сувгийн баяжуулалтад*

*анхаарч ажиллах, мөн хэвлэл мэдээлэл, сонин сэтгүүл, телевиз радио болон бусад мэдээллийн сувгаар үйл ажиллагаагаа тайлагнаж, тогтмол мэдээлэх.*

Байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах гол хэрэглүүр болох **ub.chuulga.mn** веб сайт, **Нийслэлийн Улаанбаатар чуулга** фейсбүүк хуудсаар дамжуулан санхүүгийн, хүний нөөцийн, байгууллагын үндсэн үйл ажиллагаа болох уран бүтээлийн талаарх мэдээ мэдээллийн талаар хугацаа алдалгүй тогтмол мэдээлж, сошиал мэдээллийн сувгийн баяжуулалтад анхаарч ажилласан.

*8. Тухайн байгууллагаас үзүүлдэг үйлчилгээний бүрдэл материал, хууль эрх зүй, бүрдүүлэх бичиг баримт, шат дамжлага, зарцуулах хугацаа, данс, төлбөр хураамж, албан хаагчдын мэдээлэлд өөрчлөлт орох бүрт, цаг үеийн шинжтэй иргэнд чиглэсэн аливаа арга хэмжээний мэдээ мэдээллийг тухай бүр Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн портал [eservice.ulaanbaatar.mn](http://eservice.ulaanbaatar.mn)-ны мэдлэг мэдээллийн санг баяжуулах*

Байгууллагаас үзүүлдэг үйлчилгээний арга хэмжээний мэдээ мэдээллийг тухай бүр Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн портал [eservice.ulaanbaatar.mn](http://eservice.ulaanbaatar.mn)-ны мэдлэг мэдээллийн санг баяжуулж ажиллаж байна.

*9. Чуулгын тайзнаа найруулан тавьсан уран бүтээл болон уран бүтээлчдийн тайлан тоглолтуудын бүрэн хэмжээний бичлэгийг мэргэжлийн түвшинд хийж, байгууллагын архивт сан үүсгэн хадгалах.*

2019 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр чуулгын гоцлол дуучин, МУСТА М.Анхтуяа “Тэгш дүүрэн жаргалтай яваарай” тоглолт, 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Монгол цэргийн бахархлын өдөрт зориулсан дуучин, СТА Ж.Буянтогтох “Ижилгүй монгол орон” тоглолт, 2019 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн бүжигчин Ж.Номгонмаа “Тэргэнцэртэй бүжигчин” тоглолт, 2019 оны 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар 01-ний өдрийн “Маугли” хүүхдийн циркчилсэн тоглолт, 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн үндэсний хөгжмийн “Хангарьд” найрал үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойн “Хүндэтгэлийн тоглолтуудын бичлэгийг мэргэжлийн түвшинд хийж, байгууллагын архивт хадгалсан.

*10. Байгууллагын ажилтан, албан хаагч, нийт уран бүтээлчдэд зориулсан эрүүл мэндийн сургалт зохион байгуулж, уран бүтээлчдийг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.*

2019 оны 6-р сарын 5-10-ний хооронд байгууллагын албан хаагч нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, Лабораторийн шинжилгээг Эрүүл мэндийн даатгалын гэрээт байгууллага болох "Өнөр Үжин" ХХК-нийн лаборатори, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг Этүгэн Их сургуулийн эмч нарын баг, сургалтыг мөн Этүгэн их сургуультай хамтран зохион байгуулж ажилласан.

*11. Засгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/335 дугаар захирамжийн дагуу байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон цаг хугацаанд нь холбогдох байгууллагуудад тогтмол хүргүүлж ажиллана.*

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/335 дугаар захирамжид тусгагдсан стандартын дагуу байгууллагын үйл ажиллагааны тайланг бэлтгэн НЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс болон НСУГ-т улирал бүр хүргүүлэн ажилласан.

*12. Монгол Улсын Засгийн газар, НИТХ, НЗДТГ-аас Соёл, урлагийн чиглэлээр батлагдан гарсан тогтоол, шийдвэр, албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллана.*

Монгол Улсын Засгийн газар, НИТХ, НЗДТГ-аас Соёл, урлагийн чиглэлээр батлагдан гарсан тогтоол, шийдвэр, албан даалгаврыг цаг тухай бүр нь хэрэгжүүлж ажиллаж байна.

13. Баримт бичгийн урсгалыг нэгдсэн зохион байгуулалтад шилжүүлж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд тогтмол хяналт тавьж ажиллана.

Улаанбаатар чуулга нь [egr.ulaanbaatar.mn](http://egr.ulaanbaatar.mn) цахим программын Өргөдөл, гомдлын системийг ашиглан өргөдөл, гомдлыг бүртгэж хянан шийдвэрлэдэг.

Тус чуулга нь мэргэжлийн урлагийн байгууллага бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан иргэдээс ажилд орох хүсэлт, албан хаагчдаас ажлаас түр болон бүр чөлөөлөгдөх хүсэлтүүд, бусад ажлын гүйцэтгэл, сахилга бат, нийгмийн байдлыг шийдвэрлүүлэх хүсэлтүүд ирснээр чуулгын дарга тухайн өргөдөлтэй танилцан шаардлагатай тохиолдолд чуулгын захиргааны зөвлөл болон уран сайхны зөвлөл хуралдан шийдвэрлэдэг. 2019 онд 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар өргөдөл гомдлын системд нийт 18 өргөдөл бүртгэгдсэнээс ажилд орох 11, ажлаас чөлөөлөгдөх 5, жирэмсний амралт авах 1, цалингүй чөлөө хүссэн 1 өргөдөл байсан бөгөөд эдгээр өргөдлийг 89 хувьтай шийдвэрлээд байна.

*14. Байгууллагын Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллана*

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг [edoc.ub.gov.mn](http://edoc.ub.gov.mn) вебээр хөтлөн, “Нийслэлийн архивын газрын сургалтанд тогтмол хамрагдан мэдээллийг захиргааны албан хаагч нарт хүргүүлэн ажиллаж, ирсэн явсан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар бүр гарган байгууллагын удирдлагад тайлагнан ажиллаж байна. 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн архивын газраас Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг тус чуулга дээр зохион байгуулагдаж 89% “В” үнэлгээ авсан ба үүрэг болгож өгсөн заавар зөвлөмжийг мөрдөн ажиллаж байна.

*15. Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд урлагийн захиалгат тоглолтууд, тайзны түрээс, Улаанбаатар чуулгын уран бүтээлчдийн концерт, жүжиг, мюзикл, 2018 онд тайзнаа тавихаар төлөвлөсөн төлөвлөгөөт тоглолтын орлогоос нийслэлийн төсөвт төвлөрүүлж урсгал зардлаа санхүүжүүлэх.*

Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар урлагийн захиалгат - 242, гадаадад тоглосон 19, тайзны түрээсээр үйл ажиллагаа зохион байгуулсан - 88, чуулгын байрнаа зохион байгуулсан өөрийн 61 тоглолтыг зохион байгуулж ажилласан бөгөөд энэхүү ажлуудаас нийслэлийн төсөвт нийтдээ 131.746.000 төгрөгийг төвлөрүүлэн ажиллаа.

*16. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана*

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг байгууллагын вэб сайтад сар, улирал бүрээр байршуулж ажиллаж байна.

*17. Улаанбаатар хотын 380 жилийн ойд зориулан “Их хотын дуу”, “Их хотын бүжиг”, “Их хотын хөгжим” цуврал тоглолтуудыг зохион байгуулна.*

НЗДТГ-аас дээрх тоглолтуудыг нэгтгэн нэг тоглолт болгон тоглох үүрэг өгсөний дагуу Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойн ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран 2019 оны 10 дугаар сарын 18-ний өдөр “Их хотын аялгуу” нээлтийн хүндэтгэлийн тоглолтыг өөрийн тайзнаа тоглож, Нийслэлийн 9 дүүргийн 3500 гаруй ард иргэдэд Улаанбаатар чуулга нь тус тоглолтыг доорх хувиарын дагуу тоглож үзүүлсэн. Үүнд:

- 11 дүгээр сарын 08-нд Сүхбаатар дүүрэг
- 11 дүгээр сарын 11-нд Баянгол дүүрэг
- 11 дүгээр сарын 12-нд Баянзүрх дүүрэг
- 11 дүгээр сарын 13-нд Чингэлтэй дүүрэг
- 11 дүгээр сарын 14-нд Сонгинохайрхан дүүрэг
- 11 дүгээр сарын 18-нд Багануур дүүрэг
- 11 дүгээр сарын 19-нд Налайх дүүрэг
- 11 дүгээр сарын 20-нд Багахангай дүүрэг
- 11 дүгээр сарын 21-нд Хан-Уул дүүрэгт тус тус тоглосон.

**18. Өөрийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлж ажиллана.**

Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар урлагийн захиалгат - 242, гадаадад тоглосон 19, тайзны түрээсээр үйл ажиллагаа зохион байгуулсан - 88, чуулгын байрнаа зохион байгуулсан өөрийн 61 тоглолтыг зохион байгуулж ажилласан бөгөөд энэхүү ажлуудаас нийслэлийн төсөвт нийтдээ 131.746.000 төгрөгийг төвлөрүүлэн ажиллаа.

**Гурав: Иргэдийн оролцоотой –Хөгжлийн жил-ийн 2019 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан**

**1. Нийслэл хотыг тойрсон орон нутаг болон нийслэлийн алслагдсан дүүргийн ард иргэдэд хүрч үйлчлэх замаар орлого нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулна.**

Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн ойн ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран 2019 оны 10 дугаар сарын 18-ний өдөр “Их хотын аялгуу” нээлтийн хүндэтгэлийн тоглолтыг өөрийн тайзнаа тоглож, Нийслэлийн 9 дүүргийн 3500 гаруй ард иргэдэд Улаанбаатар чуулга нь тус тоглолтыг доорх хувиарын дагуу тоглож үзүүлсэн. Үүнд:

- 11 дүгээр сарын 08-нд Сүхбаатар дүүрэг
- 11 дүгээр сарын 11-нд Баянгол дүүрэг
- 11 дүгээр сарын 12-нд Баянзүрх дүүрэг
- 11 дүгээр сарын 13-нд Чингэлтэй дүүрэг
- 11 дүгээр сарын 14-нд Сонгинохайрхан дүүрэг
- 11 дүгээр сарын 18-нд Багануур дүүрэг
- 11 дүгээр сарын 19-нд Налайх дүүрэг
- 11 дүгээр сарын 20-нд Багахангай дүүрэг
- 11 дүгээр сарын 21-нд Хан-Уул дүүрэгт тус тус тоглосон.

**2. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан тайлбарт тоглолтуудыг зохион байгуулах.**

Улаанбаатар чуулгын уран бүтээлч Битбокс Рей /Нарандэлгэр/, Монголын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран "СОЁЛЫГ ТҮГЭЭЕ" нэртэй арга хэмжээг өсвөр насны охидууд болон ээж нарт зориулан орон нутгуудаар хийлээ. "СОЁЛ ТҮГЭЭХ" бол зөвхөн өв

соёл, биет бус өв соёлын үнэ цэнэ бус харин олон нийтэд мэдлэг, мэдээлэл олгох, сургах хөгжүүлэх юм. Энэхүү ажлыг монголын 21 аймгаар хийх төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Улаанбаатар циркийн бүтээлч хамт олон Улаанбаатар чуулгатай хамтран “**Мауглитай танилцсан нь**” хүүхэд залуучуудад зориулсан циркчилсэн тайзны тоглолтыг 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл өөрийн тайзнаа тоглосон. Тоглолтыг Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 5-8-р ангийн 1000 гаруй сурагч нар ирж үзсэн. Энэ удаагийн тоглолтын онцлог нь циркийн тойрог манеж бус мэргэжлийн урлагийн тайзан дээр хийж байгаагаараа Монголдоо анхдагч нь болж байна.

Тус бүтээл нь Швецарийн хөгжлийн агентлагийн төслийн шалгаруулалтад орж шалгараад санхүүжилт авснаар тус бүтээлийн бэлтгэл ажлууд амжилттай хангагдаж, Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад амжилттай тоглогдлоо.

**2019 онд чуулгын урын санг баяжуулах зорилгоор гоцлол дуучид, хөгжимчид, циркчидын шинэлэг хэлбэрийн урсгал чиглэлээр шинэчлэн найруулсан тоглолтоо ард иргэддээ хүргэсэн байдлаас .**

2019 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр гоцлол дуучин МУСТА Мижиддоржийн Анхтуяа “Тэгш дүүрэн жаргалтай яваарай” уран бүтээлийн тоглолтоо хийж үзэгч түмэндээ хүргэлээ.



2019 оны 3 дугаар сарын 8-ны өдөр “Мартын 8 буюу-Хаврын уянга” тоглолтонд чуулгын урын санд шинээр оруулж байгаа хөгжмийн 3, дууны 3, бүжгийн 3 бүтээлээс бүрдсэн хавар цагийн нээлтийн үзэгч олондоо өргөн барилаа. Дашрамд дурдахад энэхүү тоглолтоо Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Нийслэлийн засаг даргын Тамгын газраас санаачлан зохион байгуулсан “Нэг зүрх – Нэг Нийслэл” аяны хүрээнд нийслэлийн Баянзүрх, Сонгино хайрхан, Баянгол дүүргийн 200 өрх толгойлсон, олон хүүхэдтэй, зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг үнэ төлбөргүй тоглолт үзүүлж, НИТХ-ын зарим нэг төлөөлөгчидтэй хамтран ажиллаж тоглолтоо амжилттай зохион байгуулсан.



2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Монгол цэргийн бахархлын өдөрт зориулсан дуучин, МУСТА Ж.Буянтогтох “Ижилгүй монгол орон” тоглолтоо үзэгчдийн хүртээл болгож, өөрийн мэргэжлийн ур чадварыг сорилоо. Тус тоглолтонд чуулгын уран бүтээлчид бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцсон бөгөөд Улаанбаатар циркийн жүжигчид урилгаар оролцож үзэгчдийн таашаал хүртсэн билээ.



Улаанбаатар циркийн бүтээлч хамт олон Улаанбаатар чуулгатай хамтран “**Мауглтай танилцсан нь**” хүүхэд залуучуудад зориулсан циркчилсэн тайзны тоглолтыг 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл өөрийн тайзнаа тоглосон. Тоглолтыг Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 5-8-р ангийн 1000 гаруй сурагч нар ирж үзсэн. Энэ удаагийн тоглолтын онцлог нь циркийн тойрог манеж бус мэргэжлийн урлагийн тайзан дээр хийж байгаагаараа Монголдоо анхдагч нь болж байна.

Тус бүтээл нь Швейцарийн хөгжлийн агентлагийн төслийн шалгаруулалтад орж шалгараад санхүүжилт авснаар тус бүтээлийн бэлтгэл ажлууд амжилттай хангагдаж, Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад амжилттай тоглогдлоо.





Улаанбаатар чуулгын үндэсний хөгжмийн “Хангарьд” найрал үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойн “Хүндэтгэлийн тоглолт” 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдөр чуулгын тайзнаа тоглогдсон.



### **Шинэ санаачилга, үр дүн**

“Анхаа трэйвэл” ХХК, “Үж Хан” ХХК, “Мини Тоувер” ХХК, “Эм Би Зэт Ай” ХХК-тай Нийслэлийн “Улаанбаатар чуулга” хамтран 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 3 сарын хугацаанд өдөр бүр 18 цагаас гадаадын жуулчдад зориулсан ардын урлагийн тоглолтыг өөрийн тайзнаа зохион байгуулж ажилласан.





2019 оны 09 дүгээр сарын 16-26-ний хооронд АНУ-ын элчин сайдын яамтай хамтран монголд анх удаа “Next Level Hip Program” Be boy сургалтыг 10 хоногийн хугацаатай чуулгын тайзнаа зохион байгуулан ажиллаж байна. Энэхүү сургалт нь хүүхэд залуучуудын цагийг зөв боловсон өнгөрөөхөөс гадна дэлхийн хэмжээний шинэлэг /DJ, Mc, Bm, Bb, Kn/-гэсэн 5-н урсгалын сургалтыг нэг дор сурч байгаа нь монголын залуучуудад сонирхолтой бас сурч мэдэх зүйл ихтэй сургалт болж байна. Тус сургалтанд чуулгын бүжигчид хамрагдан мөн уран бүтээлч нартай хамтран шинэлэг аяыг эгшиглүүлсэн байна.



**Хувь уран бүтээлчийн үр чадварын хөгжил, дэвшил**

Уран бүтээлчдийн үр чадвар, мэргэжлийн хөгжил дэвшлийг үнэлж шагнаж, урамшуулсан байдал.

**Хүснэгт 2**

№	Уран бүтээлчийн нэр	Албан тушаал	Шагналын нэр	Огноо
1	Б.Баатархүү	Орлогч дарга	Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан”	2019
2	Д.Ганзол	Морин хуур хөгжимчин	Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан”	2019
3	Ж.Номгонмаа	Бүжигчин	Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан”	2019
4	Б.Гэрэлтуяа	Шанз хөгжимчин	Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан”	2019
5	Ц.Гансүх	Дуучин	Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан”	2019
6	Н.Бямбадорж	Дуучин	Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан”	2019
7	Д.Шижирмаа	Дуучин	Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан”	2019
8	И.Эгэлханд	Ятга хөгжимчин	Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан”	2019
9	Д.Цэвэлсүрэн	Морин хуур хөгжимчин	Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан”	2019

10	Б.Бат-Өрнөх	Морин хуур хөгжимчин	Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан”	2019
----	-------------	----------------------	---	------

Мөн чуулгын Хангарьд найрал үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойг угтан амжилттай ажилласан 4 уран бүтээлчийг (их хуур хөгжимчин Б.Эрхэмбаяр, морин хуур хөгжимчин Д.Ганзол, шанз хөгжимчин Б.Гэрэлтуяа, ятга хөгжимчин И.Эгэлханд) “Нийслэлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр, Нийслэлийн засаг даргын “Жуух бичиг”-ээр морин хуур хөгжимчин Б.Бат-Өрнөх, Д.Цэвэлсүрэн нарыг, Нийслэлийн Соёл урлагийн газрын өргөмжлөлөөр ажлын амжилт гаргаж яваа залуу уран бүтээлчдээ урамшуулах зорилгоор морин хуур хөгжимчин Ч.Адарбилгүүн, Г.Энхбат, их хуур хөгжимчин Г.Бат-Өлзий нарыг тус тус шагнаж урамшууллаа.

### **3.2 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын 2019 оны жилийн эцсийн хэрэгжилт:**

#### **1. Хүний нөөцийг чадавхжуулах**

**а/** Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт/ Албан хаагчдын хамрагдсан байдал - 85,3% нь сургалтанд хамрагдсан.

- **Албан хаагчдад хийгдсэн сургалтуудаас дурдвал:**

1. “Нийслэлийн соёл урлагийн салбарын удирдах ажилтнуудыг чадавхижуулах” сургалт
2. Ажиллагчдын ажилласан жилийн тооцоо хийх аргачлал онлайн сургалт
3. Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Авилгын эсрэг хууль болон Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сургалт
4. Улаанбаатар чуулгын ёс зүйн дүрмийн онлайн мэдээлэл сургалт
5. ХБНГУ-ын бүжиг дэглээч Фолкер Айзенах МАСТЕР КЛАСС сургалт
6. “Монголын Улсын Зохиогчийн эрхийн тогтолцоог сайжруулах нь” Үндэсний семинар
7. “Ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл мэндийн зөв дадал, зуршил” сургалт
8. “Гэр бүлийн боловсрол” сургалт
9. Гамшгаас хамгаалах анхан шатны дадлага сургалт
10. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналтын картыг нэвтрүүлэх нь” сургалт -
11. “Ил тод худалдан авах ажиллагаа-2019” сургалт

**б/** Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх

2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 58 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс 77,6 хувь нь буюу 45 албан хаагч 3-аас дээш жил тус чуулгад ажиллаж байгаа болно.

Хэрэгжилт: 100%

#### **1. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах**

**а/** Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх

Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо:

- Монгол улсын Засгийн газрын шагнал “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулсан 10 албан хаагч (морин хуур хөгжимчин Д.Ганзол, шанз хөгжимчин Б.Гэрэлтуяа, ятга хөгжимчин И.Эгэлханд, дуучин Ц.Гансүх, дуучин Д.Шижирмаа, дуучин Н.Бямбадорж, орлогч дарга Б.Баатархүү, бүжигчин Ж.Номгонмаа, морин хуур хөгжимчин Б.Бат-Өрнөх, морин хуур хөгжимчин Д.Цэвэлсүрэн )-ийг

байгууллагын дотоод журамд заасны дагуу мөнгөн шагналаар тус тус урамшуулж шагнасан. Хэрэгжилт: 100%

*Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах:*

- Албан хаагчдын цалингийн шатлалыг ажилласан жилтэй нь уялдуулан ахиулдаг ба тайлант хугацаанд 3 албан хаагч байгаа бөгөөд эдгээр гурван албан хаагчийн үндсэн цалинг журамд заасны дагуу шатлал ахиулан олгож эхэлсэн. Зэргийн нэмэгдэл нягтлан бодогч С.Эрдэнэцэцэг, архивын эрхлэгч Б.Сувд-Эрдэнэ нар авч байсан бол энэ оны 4-р сараас эхлэн дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Өнөрцэцэг мэргэжлийн зэрэг авч баталгаажсанаар зэргийн нэмэгдэл авч эхэлсэн. Хэрэгжилт: 100%

б/ Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал

Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн судалгааг бичгээр санал асуулга хийгээгүй байна. Ажлын байранд 1-4 дүгээр сард сантехникийн таагүй үнэр ялгарч албан хаагчдаас удаа дараа гомдол гарч байсан бөгөөд тухай бүр нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт хандаж, шаардлага тавьж байсны үр дүнд бохирын шугамд гарсан гэмтлийг илрүүлж засварласнаар ажиллах нөхцөл таатай хэвийн болсон. Харин цэвэрлэгээ үйлчилгээний хувьд өдөр бүр хийгдэж байгаа. Хөгжим, дуу ангийн 8 уран бүтээлч боловсролын зэрэг дэвээ ахиулах зорилгоор Сити их сургуулийн урлаг судлалын магистрын ангид суралцаж төгссөн, мөн захиргаа ангиас 2, тайз ангиас нэг албан хаагч мэргэжлийн зэргээ ахиулах зорилготой их дээд сургуульд суралцаж байгаа бөгөөд эдгээр албан хаагчдад ажлын цагийн зохицуулалтыг хийж, хүсэлт гаргасан албан хаагч бүрт буцалтгүй тусламж олгосон. Албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж тоглолтын хуваарийг оновчтой зохион байгуулсан. Хөгжмийн зэмсгийн болон техник аппаратурын засвар үйлчилгээг батлагдсан төсвийн хүрээнд хийгдэж байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлсөн зөрчил гараагүй. Хэрэгжилт: 80%

Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх:

- Албан хаагчдад сар бүр тогтмол хоол, унааны мөнгийг батлагдсан төсвийн хүрээнд олгож байна. Байгууллагын дотоод журамд заасан албан хаагчдын унаа, хоолны зардлыг 2020 оноос нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлж судалгаа хийж байна. Хэрэгжилт: 100%

в/ Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх

2019 оны 6-р сарын 5-наас эхлэн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг эхэлж 3 үе шаттайгаар албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалан ажлыг зохион байгууллаа. Үүнд:

1. Лабораторийн шинжилгээг Эрүүл мэндийн даатгалын гэрээт байгууллага болох "Өнөр Үжин" ХХК-нийн лабораторитой хамтран цусны дэлгэрэнгүй шинжилгээ, шээсний дэлгэрэнгүй шинжилгээ, биохимийн шинжилгээ болон зүрхний цахилгаан бичлэг, хэвлийн хөндийн ЭХО гэсэн 5 төрлийн шинжилгээг хийлгэсэн.



2. Шинжилгээний хариу гарсны дараа 2-р шатны үйл ажиллагаа болох нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг Этүгэн Их сургуулийн эмч нарын багтай хамтран зохион байгуулж, тус эмч нарын багийн ахлагч анагаах ухааны магистр, дотрын тэргүүлэх зэргийн эмч М.Болд эмнэлгийн үзлэгээр орсон албан хаагчдад эрүүл мэндийн зөвлөгөө өгч, нэгдсэн дүгнэлтийг гарган байгууллагын хүний нөөцийн менежерт хүлээлгэн өгсөн.
3. Дараагийн шатны үйл ажиллагаа болох албан хаагчдад эрүүл мэндийн талаар мэдлэг олгох сургалтыг Consumer Education Center байгууллагатай хамтран 2019 оны 6 дугаар сарын 18-нд “Ажлын байран дах хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв, дадал зуршил” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгууллаа.
4. Архидалт ба бусад донтолтууд нэртэй сургалтыг нийт албан хаагч нарт 2019 оны 10 дугаар сарын 10-ний өдөр Соён гэгээрүүлэгч лектор Ж.Цогтсугараар оруулсан. Тус сурагт нь албан хаагч нарт оюун санаа, ухамсарт нь нөлөөлөх байдлаар архины хэрэглээ, мансууруулах бодис хэрэглэхийн хор уршгийн талаар дэлгэрэнгүй сураглт орсон.



### 3.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл

Улаанбаатар чуулга нь ер.ulaanbaatar.mn цахим программын Өргөдөл, гомдлын системийг ашиглан өргөдөл, гомдлыг бүртгэж хянан шийдвэрлэдэг.

Тус чуулга нь мэргэжлийн урлагийн байгууллага бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан иргэдээс ажилд орох хүсэлт, албан хаагчдаас ажлаас түр болон бүр чөлөөлөгдөх хүсэлтүүд, бусад ажлын гүйцэтгэл, сахилга бат, нийгмийн байдлыг шийдвэрлүүлэх хүсэлтүүд ирснээр чуулгын дарга тухайн өргөдөлтэй танилцан шаардлагатай тохиолдолд чуулгын захиргааны зөвлөл болон уран сайхны зөвлөл хуралдан шийдвэрлэдэг.

Байгууллагын захиргаанд хандаж гаргасан нийт **18** өргөдлөөр ирсэн хүсэлтийн 18-ууланг нь хугацаанд нь, зөрчилгүй шийдвэрлэсэн. Шийдвэрлэлттэй холбоотой гомдол гараагүй, иргэдээс гомдол ирээгүй.


Бүх албан хаагчдын нэгдсэн хурал дээр өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн үйл явцын талаарх мэдээллийг хүргэсэн. “Хүний нөөцийн систем” дээр чуулгын 15 албан хаагчийн мэдээллийг шинэчлэн оруулсан.

Тайлант хугацаанд буюу 2019 оны 01 дүгээр сарын 02-ноос 2019 оны 12 дугаар сарын 20-ны хооронд тус чуулгад нийт ирсэн өргөдлийн тоог өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулан хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 3**

Д/д	Ангилал	2018 он		2019 он	
		Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл, гомдлын хувь	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл, гомдлын хувь
1	Ажилд орох хүсэлтийн тухай	8	33.3%	11	61.2%
2	Ажлаас чөлөөлөгдөх тухай	11	45.83%	5	27.8%
3	Цалинтай чөлөө хүсэх тухай	2	8.33%	-	-
4	Цалингүй чөлөө хүсэх тухай	1	4.16%	1	5.5%
5	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	2	12.5%	-	-
6	Жирэмсний амралтын тухай			1	5.5%
<b>Нийт өргөдөл, гомдлын дүн</b>		<b>24</b>	<b>100%</b>	<b>18</b>	<b>100%</b>

Өргөдөл гомдол хүлээн авсан, шийдвэрлэсэн байдлыг графикаар үзүүлбэл:



### 3.4 Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл

Д/д	Улс, хот	Албан тушаал	Хүний тоо	Хугацаа	Зорилго	Үр дүн
1	БНСУ Сөүл хот	Дуучин Д.Шижирмаа	1	2019/01/01 2019/01/07	Ардын урлагийн наадам /БНСУ /	Монголын ардын урлагийг сурталчилсан
2	БНХАУ	Бит бокс Рей /Б.Нарандэлгэр/	1	2019/01/04 2019/01/10	Харбин Олон улсын мөсний наадам /Монголын мөсөн урлалын барималчдын урилгаар/	Монголын бит бокс урлагийг сурталчилсан
3	БНХАУ ӨМӨЗО	Дуучин О.Анхчимэг, лимбэ хөгжимчин Б.Мягмарцэрэн, ёочин хөгжимчин Х.Бархүү, Их хуур хөгжимчин Б.Эрхэмбаяр, морин хуур хөгжимчин Д.Ганзол, С.Даваажаргал, шанз хөгжимчин Б.Гэрэлтуяа, ятга хөгжимчин И.Эгэлханд	8	2019/01/13 2019/01/16	БНХАУ ӨМӨЗО Одон телевизийн бичлэгт /UBS TV-ийн урилгаар/	Монголын ардын урлагийг сурталчилсан
4	БНХАУ ӨМӨЗО	Дуучин С.Ганзориг	1	2019/01/17 2019/01/23	БНХАУ ӨМӨЗО Одон телевизийн бичлэгт /UBS TV-ийн урилгаар/	Монголын ардын урлагийг сурталчилсан


5	ӨМӨЗО Хөх хот	Дуучин Б.Батболд Дуучин О.Анхчимэг	2	2019/01/24 2019/01/28	БНХАУ Шилийн гол аймгийн Одон телевизийн бичлэг /Шилийн голын Одон ТВ-н урилгаар/	Монголын ардын урлагийг сурталчилсан
6	Швей- царь улс	морин хуурч А.Мөнгөн, дуучин Д.Шижирмаа, бүжигчид Н.Норовбанзад, Э.Чаминчулуун, Ч.Мэндсайхан, Б.Цэвэлсүрэн, уран нугараач Гүнжинлхам, Агиймаа	9	2019/01/27 2019/02/05	Швейцарь улсад болсон олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн /БОАЖЯ-ны урилгаар/	Монголын ардын урлагийг сурталчилсан
7	ХБНГУ- ын Берлин хот	Морин хуур хөгжимчин Б.Бат- Өрнөх, дуучин М.Анхтуяа, ёочин хөгжимчин Ч.Марал-Од, ятга хөгжимчин Н.Отгончимэг, бүжигчин Ж.Номгонмаа	5	2019/03/02 2019/03/15	ХБНГУ-ын Берлин хотноо “Аи Ти Би Берлин” 2019 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн /НЗДТГ-НАЖГ/	Монголын ардын урлагийг сурталчилсан
8	ОХУ Эрхүү хот	Морин хуурч А.Мөнгөн, дуучин Д.Шижирмаа, бүжигчин Г.Азаяа	3	2019/03/26 - 2019/04/01	ОХУ-ын Эрхүү хотгоо зохиогдсон “Байкал Тур” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн /НЗДТГ - НАЖГ/	Монголын ардын урлагийг сурталчилсан
9	Япон улс	морин хуурч А.Мөнгөн, Д.Ганзол	2	2019/05/05 2019/05/20	Япон улс: Дэлхийн морин хуурын холбооноос зохион байгуулсан Монгол Улсын хорт хавдартай хүүхдүүдэд эмнэлгийн тоног төхөөрөмжөөр туслах хандивын тоглолт. /Дэлхийн морин хуурын холбоогы урилгаар/	Монголын ардын урлагийг сурталчилсан
10	БНСУ	Бүжигчин Ж.Номгонмаа	1	2019/05/05 2019/05/20	БНСУ Сөүл хот. Сөүл Улаанбаатар хотын соёлын солилцооны хамтарсан тоглолт /МУЗ-ийн урилгаар/	Монголын ардын урлагийг сурталчилсан

11	Хонг Конг	Морин хуурч А.Мөнгөн, дуучин Д.Шижирмаа	2	2019/06/13 2019/06/17	Хонг Конг: “Травэл Экспо” үзэсгэлэн яармаг /Монголын хувийн компанийн урилгаар/	Монголын ардын урлагийг сурталчилсан
12	БНХАУ: Ордос хот	Чуулгын 35 уран бүтээлч оролцсон.	35	2019/06/19 2019/06/26	БНХАУ: Ордос, Улаан цав хотуудад Монгол Улсын Улаанбаатар хотын Аялал жуулчлалыг сурталчилах өдөрлөг /НЗДТГ-НАЖГ/	Монголын ардын урлагийг сурталчилсан
13	Бүгд Найрамдах Тайланд Улс:	Бит бокс Б.Нарандэлгэр, цохивор хөгжимчин Б.Дуулал	2	2019/08/17 2019/08/25	Дэлхийн 13 орны 32 уран бүтээлчдийн нэгдсэн “American music” наадам /АНУ-ын ЭСЯ-ны төслөөр/	Монголын урлагийг сурталчилсан
14	БНХАУ Улаан цав, Жинин хот	Этник дуучин Д.Шижирмаа, морин хуурч Т.Батдорж, бүжигчин Э.Балжинням, О.Оюун-Эрдэнэ	4	2019/09/03 - 2019/09/11	Олон улсын үзэсгэлэн /БОАЖЯ/	Монголын ардын урлагийг сурталчилсан
15	БНСУ Бусан хот	Бүжигчин Б.Норовбанзад, Ж.Номгонмаа, О.Оюун-Эрдэнэ, Б.Цэвэлсүрэн, Э.Балжинням, Ч.Мэндсайхан, Б.Эрдэнэсайхан, найруулагч П.Урнаа, дарга Р.Мөнхсайхан	9	2019/10/22 - 2019/10/25	БНСУ, Бусан хотын Урлагийн ажилтны холбоо, Соёл урлагийн байгууллагаас зохион байгуулдаг 57 дахь удаагийн “Бүжгийн урлагийн наадам” /Бусаны Урлагийн ажилтны холбооны урилгаар/	Монгол ардын бүжгийн урлагийг сурталчилсан
16	Тайвань	Этник дуучин Д.Шижирмаа	1	2019/11/06 - 2019/11/12	“Олон улсын экспо” /БОАЖЯ-АЖХТөвийн урилгаар/	Монголын ардын урлагийг сурталчилсан

### **Уран бүтээлчдийн гадаад улс орнууд руу хийсэн тоглолтууд**

2019 оны 06 дугаар 24-нд БНХАУ-н Ордос хотын Камбаши төв тетарт Улаанбаатар хотын соёл аялал жуулчлалыг сурталчлах, эзэн чингис хааны онгонд зориулсан тоглолтод чуулгын уран бүтээлчид оролцсон.





2019 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Улаанцав хотын тетарт БНХАУ, ОХУ, МУ-ын аялал жуулчлал хариуцсан сайд нарын 4-р хуралдаан болж, гурван улсын хамтарсан урлагийн тоглолт болсон.



БНСУ-ын Чонжү хотын Чүнбүг ардын урлагийн холбоотой 2018 оноос эхлэн хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байгаа билээ. 2018 оны 07 дугаар сарын 06-ний өдөр Улаанбаатар хотод “Солонго” нэртэй хамтарсан тоглолтыг зохион байгуулсан ба 2019 оны 08 дугаар сарын 22-26-ны хооронд БНСУ-ын Чонжү хотноо дахин хамтарсан тоглолтыг зохион байгуулж Улаанбаатар чуулгын 8 уран бүтээлч оролцоод ирсэн.



2019 оны 09 дугаар сарын 02-ны өдрөөс 09 дугаар сарын 10-ний хооронд БНХАУ-ын Жининь хотод зохион байгуулагдах “Олон Улсын үзэсгэлэн 2019” арга хэмжээнд этник дуучин Д.Шижирмаа, бүжигчин Э.Балжинням, Оюун-Эрдэнэ нар оролцоод ирсэн.



### **3.6 Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээний биелэлт:**

Төсвийн ерөнхийлөн захирагч, Төсвийн шууд захирагч нарын байгуулсан үр дүнгийн гэрээнд заагдсан ажлуудыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэж 94,8 хувийн биелэлттэй байгаа бөгөөд мэдээ тайланг НЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

### **3.7 Архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалт**

Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэсэн тухай

-“Улсын үзлэг явуулах тухай” Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Архивын тухай хуулийн 9 зүйлийн 9.5.1, Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 150 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамж, 2019 оны 07 дугаар сарын 01-ний А/13 дугаар тушаалаар улсын үзлэгт бэлтгэх ажлыг зохион байгуулах комиссыг дарга Р.Мөнхсайханаар ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Улсын үзлэгийн бэлтгэл ажлын хангуулахаар Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан сургалтанд Архивын эрхлэгч Б.Сувд-Эрдэнэ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Өнөрцэцэг, Түмэндэлгэр нар 2019 оны 06 дугаар сарын 12 болон 18, 2019 оны 08 дугаар сарын 20-ний удаа, тус тус сургалтанд хамрагдсан. Байгууллагын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Өнөрцэцэг нь Нийслэлийн архивын газраас зохион байгуулсан архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт болгонд идэвхитэй хамрагдаж, байгууллагын захиргааны албан хаагч нарт албан хэрэг хөтлөлтийн 2 удаагийн сургалт зохион байгуулсан.

### **“Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа”-нд явуулах улсын үзлэгт бэлтгэхээр:**

1. Байгууллагын зорилт, чиг үүрэг, ирээдүйн дүр төрхийг тодорхойлон тогтоосон байдал
2. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг дүгнэх үзүүлэлт, аргачлал
3. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, цахим сан бүрдүүлж буй ажлыг дүгнэх үзүүлэлт, аргачлал
4. Байгууллагын архивын ажлыг дүгнэх үзүүлэлт, аргачлал чиглэлийн 96 ажил хийхээр төлөвлөгөө гарган ажилласан.

- Улсын үзлэгт бэлтгэх комисс ажлын явцад сар бүр тогтмол төлөвлөгөөний гүйцэтгэл, бэлтгэл ажлын явцад хяналт тавьж ажилласан.
- Комиссын гишүүд урьдчилсан үзлэг байгууллагын нийт албан хаагчдын баримт бичиг боловсруулалт болон архивын баримтанд үзлэг, хийж, шаардлагатай ажлуудын жагсаалтыг гаргасан.
- Үзлэгийн дөрвөн үндсэн чиглэлийн дагуу дүгнэх үзүүлэлтийн талаар мэдээлэл бэлтгэж комиссын хурлаар хэлэлцүүлж, хариуцан бэлтгэх ажилтанд хуваарилан үзлэгийн 4 шалгуур үзүүлэлтийн дагуу хяналтын цонхыг хугацаанд нь бөглөж явуулсан.
- Архивт хадгалагдаж байгаа нийт баримтанд нягтлан шалгалт хийж байнга хадгалах баримт түр хадгалах баримт холилдож архивлагдсан байсныг ангилж, ялган архивласан.
- Байнга хадгалах 2006-2010 оны 71 хадгаламжийн нэгж шилжүүлж 2015 оны 07 сарын 02-ны өдөр баримтаа шилжүүлэн акт авсан. 2011-2014 оны байнгын баримтын бүртгэл байгууллага дээрээ Нийслэлийн архивын газрын батлагдсан бүртгэлээр хадгалагдаж байна .Мөн тусгай төрлийн баримт болох гэрэл зургийн 16 dvd Дүрс бичлэгийн 33 dvd шилжүүлсэн байна.
- Албан хэрэгт тогтмол ашиглаж байгаа компьютер, түүний үйлдлийн системийн найдвартай байдал, аюулгүй ажиллагааг хангахын тулд лицензтэй үйлдлийн систем болон вирусын програмыг зайлшгүй шаардлагатай компьютер нэг бүрт худалдан авч суулгасан.
- Улсын үзлэгт бэлтгэл ажлын хүрээнд нийт 1,876,550 төгрөг зарцуулсан.

“Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлт”-ийн Улсын үзлэгийн тухайд **89,6 /В/-** үнэлгээ авч заавар зөвлөмжийн дагуу ажиллаж байна.

***Албан хэрэг хөтлөлт, ирсэн, явсан бичгийн шийдвэрлэлтийн байдал:***

Тус газар нь албан хэрэг хөтлөлтийн баримт бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа буй бичгийг хариуцсан албан хаагч нь шийдвэрлэлтийн талаар явцын тэмдэглэл хөтөлж байна. Албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, архивлалт, хяналт, тайлагналт, хэвлэмэл хуудасны захиалга, лавлах бүртгэлийн үйл ажиллагааг [www.edoc.ub.gov.mn](http://www.edoc.ub.gov.mn) онлайн албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр хөтлөн явуулж байна. Баримт бичигт шийдвэрлэх хугацааг заасан, дурдсан хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа буй бичгийг хариуцсан албан хаагч нь ажлын өдрүүдэд шийдвэрлэлтийн талаар явцын тэмдэглэл хөтөлж байна.

- Байгууллагад ирсэн нийт бичиг 210
- Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр бүртгэгдсэн бичгийн тоо 0
- Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо 4
- Системээр бүртгэгдсэн бичгийн тоо 60
- Хуваарилагдаагүй бичгийн тоо 0
- Хариутай бичгийн тоо 65
- Хугацаандаа шийдвэрлэгдсэн 60
- Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 96,1
- Хариугүй бичгийн тоо 5
- Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 5
- Судалж байгаа 2
- Явуулсан бичиг 195, хариутай 16, хариугүй 179, цахим edoc системд 100 хувь бүртгэсэн, программ ашигладаг байгууллагуудад илгээж ажилласан. Байгууллагын албан бичгийг шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, ирсэн

бичгийг шилжүүлэх, баримт бичиг боловсруулах, баримт бичгийн эргэлт хэвийн явагдаж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

### **3.8 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа**

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа байхгүй болно.

### **3.9 “Нийслэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д тухайн жилд гаргах тайлан, мэдээний тухай мэдээлэл**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт - шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын дагуу бодлогын баримт бичиг, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна. Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар гарган, биелэлтийг НЗДТГ-ын ХШҮХ, НСУГ, “LMonitoring” програмд цахим хэлбэрээр оруулсан.

### **2019 оны Улаанбаатар чуулгын тоглолтонд оролцсон тоон мэдээлэл**

Ерөнхийлөгч	1		
Ерөнхий сайд	4	Өөрийн байранд тоглосон тоглолт:	6
Шадар сайд	1	Оролцсон уран бүтээлчид:	1.944
УИХ	11	Үзэгчдийн тоо:	10.159
МАН	6	Гадуур захиалгат ажил:	242
БСШУСЯам	5	Оролцсон уран бүтээлчид:	2.343
БОАЖ	3	Үзэгчдийн тоо:	2.161.639
ГХЯ	1	Гадаадад тоглосон тоглолтын тоо:	19
ХХНХ	1	Оролцсон уран бүтээлчид:	96
ЗТХЯ	1	Үзэгчдийн тоо:	24.296.900
НИТХ	40		
НЗДТГ, харьяа газрууд	126		
НСУГ	9		
УБЧ	113		

**Нийт ажлын тоо: 322**

**Нийт оролцсон уран бүтээлчдийн тоо: 4.383**

**Нийт үзэгчдийн тоо: 26.468.698**

### **“ДЭЭЛТЭЙ МОНГОЛ” НААДАМ**

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар хамтран 13 дэх жилдээ “Дээлтэй Монгол наадам” үйл ажиллагааг 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр 14:00-18:00 цагийн хооронд Их жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд Нийслэлийн “Улаанбаатар чуулгын уран бүтээлч Б.Нарандэлгэр оролцсон.



[Дөрөвдүгээр бүлэг “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал”](#)

**4.1 Мэдээллийн үйл ажиллагааны ил тод байдал**

- Байгууллагын мэдээллийн мэдээллийн ил тод байдлыг хангах гол хэрэглүүр болох веб сайтыг тогтмол, **ФЕЙСБҮҮК, ТВИТТЕР** хуудсын ашиглалт, үйл ажиллагаа, баяжуулалтыг сайжруулж, түүнд хяналт тавьж ажилласан.


- Чуулгын тоглолтын талаарх мэдээ, мэдээлэл, чуулгын маркетингийн зар сурталчилгааны ажлыг эрчимжүүлж, сошиал маркетингаар үзэгчдийн хамгийн их хандалттай **FACEBOOK, TWITTER, GOOGLE+, YOUTUBE CHANNEL** сувгууд болон урлагийн мэдээ мэдээллийг голчлон түгээдэг хандалт ихтэй вэб хуудсууд, сонин сэтгүүл, телевизийн үндсэн сувгуудтай хамтран ажиллаж өөрсдийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж ажилласан.



## UBS, Монгол HD, МҮОНРТ, NTV, TV5, Star Tv, TV9, C1 телевизүүдээр

- Хэвлэл мэдээллийн сурталчилгааг
  - “Зиндаа” сэтгүүл, “Нийслэл гайд”, “Засгийн газрын мэдээ”, “Нийслэл Таймс”
- Сошиал мэдээллийн сурталчилгааг
  - urlag.mn, news.mn, ikon.mn, zindaa.mn, unreadtoday.mn, arav.mn зэрэг сайтууд
- Гудамж, зам талбай, олон нийтийг хамарсан сурталчилгааг
  - Засаг Даргын Тамгын Газрын үүдний дэлгэц
  - Монголын хүүхдийн Ордны гадаах дэлгэц
  - Төв талбайн өмнөх “Нийслэл дэлгэц”
  - Зүүн хүрээ хотхоны дэлгэц
  - Л.Энэбишийн өргөн чөлөөнд байрлах “Түмэн дэлгэц”

“Улаанбаатар” чуулгын гадаах дэлгэцүүд дээр уран бүтээлийн талаарх мэдээ мэдээлэл, клип, шторк зэргийг цацаж өөрсдийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан.



### 4.2 Төсөв, санхүүгийн ил тод байдал

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэн сар бүр байгууллагын төсвийн гүйцэтгэл, улирал бүр санхүүгийн тайланг гаргаж НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлэн баталгаажуулан байгууллагын цахим хуудсанд Төсөв, санхүүгийн ил тод байдал Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудсанд шилэн дансны мэдээллийн цэс үүсгэж, шилэн дансны нэгдсэн системд 2019 оны жилийн төсөв, 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, 2019 оны 01-06 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, төсөв хөрөнгөтэй холбоотой тушаал шийвдэр, таван сая төгрөгнөөс дээш гүйлгээний орлого, зарлагын мэдээлэл болон бусад холбогдох баримт мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон шилэн дансанд байршуулж иргэд олон нийтэд нээлттэйгээр мэдээлсэн.

### 2/ Хүний нөөцийн бодлогын ил тод байдал

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг баримтлан ажилласан.

8.1.1.Сул орон тооны зарыг цахим сүлжээ болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах гэсэн заалтын дагуу:

- Чуулгын үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу уран бүтээлчдийн мэргэжлийн ур чадварыг чанаржуулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мөн уран бүтээлчдийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор төлөвлөсний дагуу 1 дүгээр улирлын сүүлийн хагасаас эхлэн сошиал хуудсуудаар дамжуулан уран бүтээлчдийн нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд хүргэж, шалгаруулалтад оролцох уран бүтээлч бүрийг нээлттэй бүртгэсэн.

Уран бүтээлчдийн нээлттэй сонгон шалгаруулалтыг 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 09:00 цагаас 23:00 цагийн хооронд зохион байгуулсан.

Тус шалгаруулалтад дуучин мэргэжлээр шалгуулах 26 уран бүтээлч, морин хуур хөгжимчин 3, ёочин хөгжимчин 1, их хуур хөгжимчин 1, эвэр бүрээ хөгжимчин 1, лимбэ хөгжимчин 1, нийт 33 уран бүтээлч шалгуулахаар бүртгүүлсэн. Удирдамжинд заасны дагуу чуулгын нийт уран бүтээлчид тус шалгалтын удирдамжийн дагуу бэлтгэлээ хангасан байсан ба нийт дуучид - 7 уран бүтээлч, хөгжимчид – 13 уран бүтээлч, бүжигчид – 9 уран бүтээлч, нийт 29 албан хаагчид шалгалтанд хамрагдсан болно. Бүжигчнээр шалгаруулалтад оролцох уран бүтээлч ирж бүртгүүлээгүй учир дахин зар тавьж бүжигчдийн орон тоог гүйцээхээр ажиллаж байна. Хийлч Ч.Дэлгэрцэцэг гадаад явах шалтгаанаар тус шалгалтыг урьдчилан өгсөн болно. Мөн бүжигчин Б.Цэвэлсүрэн арьс харшлын өвчний учир эмчийн магадлагаагаар, шитар хөгжимчин Б.Мөнхболд үе мөчний өвчний учир БНСУ-д эмчилгээ оношлогоо хийлгэхээр явсан, ёочин хөгжимчин Х.Бархүү эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байгаа шалтгаанаар албан ёсоор шалгаруулалтаас чөлөөлөгдсөн бөгөөд дуу ангийн 3 уран бүтээлч дуучин Б.Батболд, С.Ганзориг, Г.Хонгорзул, эвэр бүрээ хөгжимчин Б.Эрдэнэ-Очир нар хүндэтгэх шалтгаангүйгээр шалгаруулалтад оролцоогүй болно. Дуу ангийн 3 уран бүтээлч тус өдөр шалгалтын цаг эхэлснээс хойш гурван уран бүтээлчийн гарын үсэг бүхий шүүгчдийн зөвлөл, чуулгын захиргаанд хаягласан өргөдлийг ирүүлсэн бөгөөд тус хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх боломжгүй гэж үзсэн болно. Энэ 4 хүний талаарх асуудлыг дараа нь уран сайхны зөвлөлийн хурал, захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэхээр болсон.

Тус шалгаруулалтын ерөнхий шүүгчээр Монгол улсын Гавьяат жүжигчин, УДБЭТ-ын дарга, дуучин Ц.Төвшинтөгс, Монгол Улсын Гавьяат жүжигчин, дуучин Ц.Үенч, Улсын филармонийн ерөнхий удирдаач, Монгол улсын соёлын тэргүүний ажилтан Д.Нямдаш, Монгол Улсын Консерваторийн бүжгийн багш, Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан Н.Эрдэнэбаяр, Монгол Улсын Соёл Урлагийн Их сургуулийн багш, профессор Д.Ариунаа нарын нэр хүнд бүхий 5 шүүгч уригдаж ажилласан.





Нийт 63 уран бүтээлч шалгуулснаас гитар хөгжимчин М.Болдбаатар, beatbox Ray буюу Б.Нарандэлгэр нарыг шүүгчдийн зөвлөл хэлэлцэн онцлог уран бүтээлч гэж үзэж шалгалтанд тэнцүүлсэн бөгөөд 61 уран бүтээлчийг удирдамжийн дагуу шалгаж үнэлгээ өгч нэгтгэн боловсрууллаа.

90-100 оноо авсан бол “А” буюу “Маш сайн”	-	22/36%	
80-89 оноо авсан бол “В” буюу “Сайн”	-	14/22.9%	
70-79” оноо авсан бол “С” буюу “Хангалттай”	-	5 / 8.19%	
0-69” оноо авсан бол “D” буюу “F” үнэлгээтэй	-	20/32.7%	гэж

дүгнэгдсэн.

2019 онд жилийн эцсийн байдлаар 12 албан хаагч ажлаас бүр чөлөөлөгдсөн, жирэмсний амралтаа авсан 4 албан хаагч, нөөцөнд байсан боловсон хүчний нөөцөөс 12 иргэнийг үндсэн болон түр орон тоон дээр авч ажиллуулав. Мөн 2018 онд түр орон тоон дээр ажиллаж байсан морин хуур хөгжимчин Т.Батдоржийг ажлын ур чадвар, байгууллагын уран бүтээлийн шаардлагын дагуу үндсэн албан хаагчаар томилж ажиллуулж байна. Мөн байгууллагын дотоод ажлын шаардлагаар их хуур хөгжимчин Б.Эрхэмбаярыг туслах удирдаачийн, маркетингийн ажилтан Б.Түмэндэлгэрийг тайз үйлдвэрлэлийн ангийн даргаар томилон ажиллуулж байна. Мөн уран бүтээлчдийн нээлттэй сонгон шалгаруулалтад орж тэнцсэн морин хуур хөгжимчин Г.Энхбат, морин хуур хөгжимчин Ч.Адарбилгүүн, их хуур хөгжимчин Г.Бат-Өлзий, бишгүүр хөгжимчин О.Анар, ёочин хөгжимчин Ц.Энхмаа, морин хуур хөгжимчин Т.Санжаажамц нарын 6 уран бүтээлч, мэргэжлийн хөгжимчдийг авч ажиллуулж байгаа бөгөөд эдгээр уран бүтээлчид байгууллагын туршилтын хугацаанд амжилттай ажилласан тул туршилтын хугацаа дуусаж чуулгын үндсэн албан хаагч болоод байна. Хүний нөөцийн ил тод байдлын хувьд шинээр албан хаагч ажилд авах үйл явц олон нийтэд нээлттэй зарлагдаж, тус ажлын байрыг сонирхож ирсэн иргэнийг ярилцлага, шалгаруулалтад оруулж ажилд авч хэвшээд байна. Одоо тус чуулгын хүний нөөцөөр бүртгүүлсэн иргэний тоо 17 байна. Үүний 90 хувь нь мэргэжлийн уран бүтээлчийн орон тоон дээр ажиллах хүсэл сонирхолтой иргэд байна.

8.1.2. Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх гэсэн заалтын дагуу:

- Улаанбаатар чуулгын даргын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлагдсан Улаанбаатар чуулгын ёс зүйн дүрмийг баримтлан ажиллаж байна. Дүрмийг цахим хуудсанд байршуулсан, уран бүтээлийн анги тус бүрээр дүрэм журмын хавтас нээж албан хаагч нарт танилцуулсан. Байгууллагын мэдээллийн самбарыг шинэчлэн хийлгэсэн. Ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэл гаргасан дуучин Н.Бямбадорж, МУСТА дуучин М.Анхтуяа, МУСТА дуучин Б.Нарандэлгэр нарт Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1, 131.1.2, “Улаанбаатар” чуулгын дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сахилгын шийтгэл ноогдуулсан. Оны сүүлийн хагас ёс зүйн зөрчил гаргаж арга хэмжээ авагдсан албан хаагч байхгүй болно.



8.1.3. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх заалтын дагуу:

- Нийт уран бүтээлчдийн 2018 оны ажлын гүйцэтгэлийг хүн тус бүрээр уран сайхны зөвлөлөөр хэлэлцэж дүгнэсэн ба бүх нийтийн хурлаар албан хаагч нэг бүрт танилцуулсан. Үнэлгээг цахим хуудсанд байршуулсан. Чуулгын үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай байгаа урын сангийн баяжуулалт хийх, хөгжүүлэх шаардлагатай мэдлэг ур чадварын тухай заавар зөвлөмж өгөх, бүтээлч байдлыг дээшлүүлэх чиглэлээр санал солилцох гэх мэт чиглэлээр удирдлагаас үүрэг даалгаврууд өгөгдсөн. Мөн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөрүүдийн дагуу хийгдэх боломжтой ажлуудыг хэлэлцэж тодорхой ажлуудыг хийсэн. Дунд түвшний удирдлагуудыг албан хаагчдыг үр бүтээмжтэй ажиллуулахад анхаарч ажиллахыг үүрэг болгосон ба шаардлагатай мэргэжлийн ангид ангийн дарга нарыг шинээр томилов. Мөн уран бүтээлчдийн нээлттэй сонгон шалгаруулалтын шүүгч нарыг урлагийн нэр нөлөө бүхий томоохон төлөөлөгчдийг урьж ажиллуулсан.

8.1.4. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх заалтын дагуу:

- Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллийг мэдээллийн самбар болон сошиал сүлжээн дэх өөрийн хуудсан дээр байршуулан мэдээлж ажилласан. Байршуулж мэдээлсэн мэдээлэлүүдийг авч хадгалан дарааллын дагуу архивт өгөх баримтын хавтсанд хийж хадгалсан. Оны эцсээр жагсаалтын дагуу архивын эрхлэгчид хүлээлгэн өгнө.

8.1.5. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх заалтын дагуу:

- Албан хаагч тус бүрийн өнгөрсөн оны тайлан, 2019 оны хийх ажлын төлөвлөгөөг хийлгэж 02 дугаар сард хүн тус бүрээр хэлэлцэж батлав. Ажлын гүйцэтгэлийг дүгнэх арга зүйг 2015 онд хэлэлцэж баталсан ба үүнийг дүгнэх ажиллагаандаа ашиглаж байна. Мөн I-IV улирлын ур чадварын нэмэгдлийг албан хаагч бүрийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил хийгдсэн эсэх, өдөр тутмын үйл ажиллагаа, тоглолтын дуудлаганд хэрхэн ажилласан зэргийг харгалзан захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүгнэж олгосон.

8.1.6. Хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг мэдээлэх заалтын дагуу:

Хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн талаархи үнэн зөв мэдээллийг бэлтгэн, байгууллагын мэдээллийн самбар болон дотоод ажлын UB ENSEBMLE STAFF группээр дамжуулан албан хаагчдад цаг алдалгүй хүргэн ажиллаж байна.

- *Нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр:* Албан хаагчдын мэдлэг боловсролоо дээшлүүлж, зэрэг дэв ахихад нь дэмжлэг үзүүлж, ажлын цагийн зохицуулалт хийж, шаардлагатай албан хаагчид сургалтын төлбөрт нь дэм болох зорилгоор дизайнер Г.Чимэд, тонмейстр Ц.Батцэнгэл нарт нэг удаагийн буцалтгүй тусламжийг тэдний хүсэлтийн дагуу олгосон.

Дотоодын их дээд сургуулиудад сурч буй болон суралцаж төгссөн албан хаагчид:

<b>Хүснэгт 5</b>					
<b>№</b>	<b>Нэр</b>	<b>Сургууль</b>	<b>Мэргэжил</b>	<b>Зэрэг, дэв</b>	<b>Суралцах хугацаа, үе шат</b>
1	Архивын эрхлэгч Б.Сувд-Эрдэнэ	Тэнгэр дээд сургууль	Архив судлал	Бакалавр	3 жил /2-р курс төгссөн/
2	Бүжигчин О.Оюун-Эрдэнэ	Монгол Улсын Консерватори	Бүжгийн багш, дасгалжуулагч	Бакалавр	3 жил /2-р курс төгссөн/
3	Тонмейстр Ц.Батцэнгэл	СУИС-ийн Радио Телевизийн модулын сургууль	Дууны техник, тохиргооны инженер	Бакалавр	3 жил /2-р курс төгссөн/
4	Дизайнер Г.Чимэд	ХУИС	Англи хэлний орчуулагч	Бакалавр	3 жил /1-р курс төгссөн/
5	Шанз хөгжимчин Б.Гэрэлтуяа	Сити Их Сургууль	Урлаг судлаач	Магистр	2019-Ү сард Төгссөн
6	Ятга хөгжимчин И.Эгэлханд	Сити Их Сургууль	Урлаг судлаач	Магистр	2019-Ү сард Төгссөн
7	Морин хуур хөгжимчин А.Мөнгөн	Сити Их Сургууль	Урлаг судлаач	Магистр	2019-Ү сард Төгссөн
8	Морин хуур хөгжимчин Д.Цэвэлсүрэн	Сити Их Сургууль	Урлаг судлаач	Магистр	2019-Ү сард Төгссөн
9	Дуучин Ц.Гансүх	Сити Их Сургууль	Урлаг судлаач	Магистр	2019-Ү сард Төгссөн
10	Ятга хөгжимчин Н.Отгончимэг	Сити Их Сургууль	Урлаг судлаач	Магистр	2019-Ү сард Төгссөн
11	Морин хуур хөгжимчин Д.Ганзол	Сити Их Сургууль	Урлаг судлаач	Магистр	2019-Ү сард Төгссөн

- *Нэг удаагийн тусламж дэмжлэг:*

- Ар гэрт нь гачигдал гарсан, бага орлоготой албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж олгов.

<b>Хүснэгт 6</b>				
<b>№</b>	<b>Албан хаагчийн нэр</b>	<b>Албан тугаал</b>	<b>Шалтгаан</b>	<b>Мөнгө дүн</b>
1	О.Оюун-Эрдэнэ	Бүжигчин	Эмчилгээний зардалд	300 000
2	Г.Чимэд	Дизайнер	Сургалтын зардалд дэмжлэг үзүүлэх	200 000
3	Л.Одгэрэл	Хүний нөөцийн менежер	Хадам аав нь нас барсан	150 000
4	Б.Сувд-Эрдэнэ	Архивын эрхлэгч	Хадам аав нас барсан	150 000
4	Нийт			800 000

2018 онд хүүхдийн баяраар албан хаагчдын 0-14 насны 73 хүүхдэд 1565850 төгрөгний үнэ бүхий бэлэг өгч байсан бол, 2019 оны 6 дугаар сард Хүүхдийн баярын бэлэг болгон мөн насны 74 хүүхдэд 1858880 төгрөгний бэлэг, Шинэ жилийн баярын бэлгийг 70 хүүхдэд 1750000 төгрөгний үнэ бүхий бэлэг бэлдэж бэлэглэв.

• **Албан хаагчдад хийгдсэн сургалтууд:**

1. “Нийслэлийн соёл урлагийн салбарын удирдах ажилтнуудыг чадавхижуулах” сургалт – 2019/01/10 (НСУГ) 2/2
2. Ажиллагчдын ажилласан жилийн тооцоо хийх аргачлал онлайн сургалт – 2019/03/22
3. Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Авилгын эсрэг хууль болон Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сургалт – 2019/04 сар
4. Улаанбаатар чуулгын ёс зүйн дүрмийн онлайн мэдээлэл сургалт – 2019/05/15
5. 2019 оны 5 дугаар сарын 9-ны өдөр “Берлиний Агаарын Гүүрийн Түүхээс” төслийн хүрээнд Сонгодог ба Орчин Үеийн Бүжгийн Рамберт Сургууль болон Лондонгийн Эзэн Хааны Бүжгийн Багшийн Нийгэмлэгийг тус тус дүүргэсэн ХБНГУ-ын бүжиг дэглээч Фолкер Айзенах МАСТЕР КЛАСС сургалтанд манай чуулгын 11 бүжигчин, 1 бүжгийн багш хамрагдаж орчин үеийн бүжгийн чиглэлээр ур чадвараа дээшлүүлсэн.



6. “Монголын Улсын Зохиогчийн эрхийн тогтолцоог сайжруулах нь” Үндэсний семинар 2019/5/16-17 (Монголын Оюуны өмчийн газар) -1/1
7. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын албан ёсны агент болох Consumer Education Center сургалтын байгууллагын “Ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл мэндийн зөв дадал, зуршил” сургалтыг 2019 оны 5 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж албан хаагчдыг хамруулав. 61/47
8. Нийслэлийн ХГБХГ-тай хамтран албан хаагчдад зориулсан “Гэр бүлийн боловсрол” сургалт – 2019/05/27 (61/39)
9. Гамшгаас хамгаалах анхан шатны дадлага сургалт – 2019/06/20 (Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв)
10. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналтын картыг нэвтрүүлэх нь” сургалт - 2019/06/12 (3/3)
11. “Ил тод худалдан авах ажиллагаа-2019” сургалт (Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар) -2019/06/13 -1/1

12. Соёл урлагийн “ЗАЛУУ МАНЛАЙЛАГЧ” хөтөлбөрт морин хуур хөгжимчин Т.Батдорж хамрагдаад байна. Мөн Монголын урлагийн зөвлөлийн төгсөгчдийн дунд зарласан нийт төгсөгчдийн дунд зарласан 6 сая төгрөгийн төслийн уралдаанд Улаанбаатар чуулгын бүжигчин Ж.Номгонмаагийн санаачилсан "Орчин үеийн бүжгийн урлагаар дамжуулан тэргэнцэртэй иргэдийг дэмжих" бүжгийн төсөл шалгарч тайзны бүтээл болгон 2019 оны 9 дүгээр сарын 29нд тайзнаа тоглож, үзэгчдийн хүртээл болгосон.
13. Насанд хүрэгчдийн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 2019 оны 05 дугаар 04-ний өдөр зохион байгуулж гүйцэтгэлийг программ руу оруулж чийрэгжилтийн түвшний үнэлгээг гаргав.
14. 2019 оны 09 дүгээр сарын 16-26-ний хооронд АНУ-ын элчин сайдын яамтай хамтран монголд анх удаа “Next Level Hip Program” Be boy сургалтыг 10 хоногийн хугацаатай чуулгын тайзнаа зохион байгуулан ажиллаж байна. Энэхүү сургалт нь хүүхэд залуучуудын цагийг зөв боловсон өнгөрөөхөөс гадна дэлхийн хэмжээний шинэлэг /DJ, Mc, Bm, Bb, Kn/-гэсэн 5-н урсгалын сургалтыг нэг дор сурч байгаа нь монголын залуучуудад сонирхолтой бас сурч мэдэх зүйл ихтэй сургалт болж байна. Тус сургалтанд чуулгын бүжигчид хамрагдан мөн уран бүтээлч нартай хамтран шинэлэг аяыг эгшиглүүлэнсэн байна.



- *Олон нийтийн доорхи ажлуудад хамт олноороо идэвхитэй оролцов.*
  - 2019 оны 04 сарын 06-нд Багахангай дүүрэгт болсон НСУГ-ын харьяа газруудын “Спорт өдөрлөг”-т хамт олноороо амжилттай оролцож, спортын 4 төрлөөр тамирчдаа бэлтгэн оролцсон.
  - 2019 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр “90 минутын их цэвэрлэгээ”- Туул голын эргийг тус чуулгын албан хаагчид цэвэрлэж тайлан мэдээг Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын Албанд хүргүүлсэн.
  - 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр НЗДТГ-аас ирсэн 02-05/1689 тоот албан бичгийн дагуу “Бүх нийтээр мод тарих арга хэмжээ”-нд чуулгын 57 албан хаагч 285000 төгрөгний хандив өгч оролцов
  - 2019 оны 05 дугаар сарын 18-ний өдөр Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Улаанбаатар марафон-2019” үйл ажиллагаанд хамт олноороо идэвхитэй оролцлоо.

-Нийслэл, дүүргүүдийн Онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагаанд 24 цагаар хяналт тавьж удирдлага зохион байгуулалт, мэдээллээр хангаж ажилласан тухай

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1016 дугаар захирамжаар, 2019 оны “Түүхий нүүрсний тээвэрлэлт хэрэглээнд хяналт тавих тухай” А/1118 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн

Ажлын албаны даргын 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ түүний зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтны хуваарь”, “Нийслэл дүүргүүдийн Онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагаанд 24 цагаар хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын удирдамж”-ийн дагуу 2019 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 10:00 цагаас 12 дугаар сарын 22-ны өдрийн 09:00 цаг хүртэл Улаанбаатар чуулгын дарга Р.Мөнхсайханаар ахлуулсан 35 хүний бүрэлдэхүүнтэй 24 цагийн хариуцлагатай зохицуулагчийн үүрэг гүйцэтгэж ажилласан.

#### Тавдугаар бүлэг: “Бусад мэдээлэл”

#### ***1/ Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээлэл:***

2019 онд Улаанбаатар чуулга нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Нийслэлийн Үйлдвэрлэл, Инновацийн газар, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын Алба, Нийслэлийн Соёл, урлагийн газар, Нийслэлийн Хүүхэд, Гэр бүл хөгжлийн газар, Нийслэлийн Биеийн тамир спортын газар, Нийслэлийн Нийгмийн Халамжийн Газар, Сүхбаатар дүүргийн ИТХ, ЗДТГ, Чингэлтэй дүүргийн ИХТ, ЗДТГ, Сонгинохайрхан дүүргийн ИХТ, ЗДТГ, Нийслэлийн Татварын Газар, Нийслэлийн Онцгой байдлын Газар болон бусад Нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай захиалгат урлагийн тоглолт, тайзны үйл ажиллагаагаар хамтран ажилласан.

#### ***2/ Хөрөнгө, санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт:***

1. Шинэ уран бүтээл туурвих, тоглолт зохион байгуулах, их танхимд захиалгат арга хэмжээг зохион байгуулахад үйлчилгээний албан хаагчид /билет таслагч, заалны зохион байгуулагч/ байхгүйгээс үйлчилгээний стандарт мөрдөгдөхгүй байх, үйл ажиллагаа доголдох, харилцагч байгууллагуудаас санал гомдол ирэх /ажлын бус цагуудаар ихэвчлэн хамтрагч байгууллагуудын үйл ажиллагаа зохион байгуулагддаг/ зэрэг асуудлууд үүсдэг.

Тухайлбал: Үзвэр зохион байгуулах үеэр Улаанбаатар чуулгын Захиргааны албан хаагчид өөрсдийн зохион байгуулсан тоглолтуудад билет таслах, зохион байгуулагч, угтах хийдэг боловч гадны байгууллагаас захиалгат үйл ажиллагаа авах үед дээр үйлчилгээнүүдийг үзүүлэх боломжгүй байдаг нь үйлчилгээний байгууллагын дутагдалтай тал болдог. 2010-2013 оны хооронд тайз, байрны зохион байгуулагч болон үйлчилгээний ажилчидтай байсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2013 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/946 дугаар захирамжаар үйлчилгээний албан хаагчдыг Нийслэлийн Нийтлэг Үйлчилгээний Газарт шилжүүлсэн.

**2019 оны тайз ашиглалт:**

“Улаанбаатар чуулга”-ын үндсэн үйл ажиллагааны нэг болох тайзны уран бүтээл болон тайзны ашиглалтын байдлаар 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар томоохон 188 ажлыг амжилттай зохион байгуулж, тайзны тоглолт, захиалгат ажлуудаар давхардсан тоогоор нийтдээ 80 гаруй мянган хүн амд хүрч ажилласан.


Жилийн эцсийн ажлын тоон мэдээг өмнөх 2 онтой харьцуулан хүснэгтээр үзүүлбэл:

**Хүснэгт 7**

Тайзны ажлын тоо		2017		2018		2019	
I улирал	1 сар	4	26	7	35	3	29
	2 сар	6		6		4	
	3 сар	16		22		22	
II улирал	4 сар	18	50	20	79	18	45
	5 сар	20		31		16	
	6 сар	12		28		11	
III улирал	7 сар	5	10	6	20	16	44
	8 сар	1		1		19	
	9 сар	4		13		9	
IV улирал	10 сар	15	55	17	50	23	70
	11 сар	16		16		20	
	12 сар	24		17		27	
ДҮН			141		184		188

Дээрх хүснэгтээс харахад 2019 оны тайз ашиглалтын байдал өмнөх 2 онтой харьцуулахад ялимгүй өсөлттэй харагдаж байна. Ажлын тоогоор өсөлтийн хэмжээ бага байгаа ч чуулгын уран бүтээлийг хүргэсэн үзэгч, чуулгын тайзыг түрээслэн үйлчлүүлсэн байгууллага аж ахуйн нэгж болон үйлчлүүлэгчдийн тоо харьцангуй хэмжээгээр нэмэгдсэн, үйлчлүүлэгчийн хүрээ өргөжсөн тоон мэдээтэй байна.

**Хүснэгт 8**



2019 онд тайз ашиглалтыг харьцангуй жигд хүртээмжтэй зохион байгуулж ажиллаа. Үүний гол шалтгаан нь ачаалал эрс бага байдаг зуны саруудад жуулчдад зориулсан ардын урлагийн тоглолтыг өдөр бүр 18.00 цагаас тоглож хэвшсэн нь аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудад илүү шинэлэг таатай орчинд үйлчилгээ авах боломж нээгдсэн. Үүнийг дагаад үйлчлүүлэгчдийн тоо ч бас эрс өссөн хандлагатай харагдаж байна. Мөн чуулгын их танхим хүйтэн сэрүүний улиралд ажил үйлчилгээ явуулахад урд жилүүдэд маш тухгүй хүйтэн, үйлчлүүлэгчдийн зүгээс гомдол их ирдэг байсны дагуу авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнд тохь тухтай болсон тул үйлчлүүлэгчид бас сэтгэл ханамж өндөртэй үйлчлүүлж, үйлчлүүлэгчдийн тоо өсөх хандлагатай болсон. (Доор графикаар үзүүлэв.)



ХЯНАСАН:

ДАРГА

Р.МӨНХСАЙХАН

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН

Б.ӨНӨРЦЭЦЭГ